



2026 он 08 сар 28 өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

**Шаардах эрхийн дараалал хойшлуулах тухай гэрээнүүд
байгуулахыг зөвшөөрөх тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18, 76.2, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг болон Говь ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 6.2 дугаар зүйлийн 6.2.1, 6.2.7.15, 6.2.7.17 дахь заалтуудыг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 17 дугаар тогтоолоор Компани Азийн Хөгжлийн Банк (цаашид “АХБ” гэх)-наас эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн зориулалтаар гурван жилийн хугацаатай, 20,000,000 (хорин сая) ам.доллартай тэнцэх төгрөг хүртэлх зээл авах, холбогдох зээлийн болон барьцааны гэрээнүүдийг байгуулахыг зөвшөөрсөн болохыг тэмдэглэсүгэй.
2. Компани болон дор дурдсан зээлдүүлэгчдийн хооронд байгуулсан зээлийн шугамын гэрээнүүдийн дагуу тухайн зээлдүүлэгчдийн Компанид холбогдох аливаа шаардах эрх болон төлбөрийн шаардлагыг энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан зээлтэй холбоотой АХБ-ны Компанид холбогдох аливаа шаардах эрх болон төлбөрийн шаардлагын дараа эрэмбэлэх талаар тохиролцож, АХБ болон дор дурдсан зээлдүүлэгч тус бүртэй шаардах эрхийн дараалал хойшлуулах тухай тусдаа гэрээ (Deed of Subordination) байгуулах, тэдгээрийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхийг Компанид зөвшөөрсүгэй. Үүнд:
 - 2.1. Таван Богд Холдингс ХХК-тай байгуулсан 2023 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн 2023/01/85 дугаар Харилцан зээлийн шугамын гэрээ (2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн 2026.01-111 дугаар нэмэлт, өөрчлөлттэй);
 - 2.2. Таван Богд Фүүдс ХХК-тай байгуулсан 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Барьцаат зээлийн шугамын гэрээ; болон
 - 2.3. Таван Богд Фүүдс Пицца ХХК-тай байгуулсан 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн CA/24/0052/26 дугаар Барьцаат зээлийн шугамын гэрээ.
3. Энэхүү тогтоолын 2 дахь хэсэгт заасан шаардах эрхийн дараалал хойшлуулах тухай гэрээнүүд болон тэдгээрт оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийн нөхцөл, агуулгыг Компанийн нэрийн өмнөөс хэлэлцэн тохиролцох, тэдгээрт Компанийг төлөөлж гарын үсэг зурах, баталгаажуулах, хүргүүлэх, тэдгээрийн дагуу Компанийн хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх, мөн холбогдох мэдэгдэл, баталгаа, гэрчилгээ, маягт, хавсралт болон бусад баримт бичигт гарын үсэг зурах эрхийг дангаараа эсхүл хамтран хэрэгжүүлэх эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Амарсайхан) болон Таван Богд Холдингс ХХК-ийн Санхүү удирдлага хариуцсан захирал (Б.Оргил) нарт тус тус олгосугай.

2016 он 08 сар 28 өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

4. Энэхүү тогтоолын 2 дахь хэсэгт заасан хэлцлүүд нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тул тэдгээрийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн сонирхлын зөрчилгүй, хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар зөвшөөрч, баталсугай.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:



Д.ГЭРЭЛМАА

Р.САРАНЦЭЦЭГ

Д.ХҮРЭЛБААТАР

2026 он 08 сарын 28 өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох, гарын үсэг зурах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18, 76.2, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг болон Говь ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 6.2 дугаар зүйлийн 6.2.1, 6.2.7.15, 6.2.7.17 дахь заалтуудыг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

1. Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох Таван Богд Холдингс ХХК-ийн Азийн Хөгжлийн Банк (цаашид “АХБ” гэх)-тай байгуулах 30,000,000 (гучин сая) ам.доллар эсхүл түүнтэй тэнцэх төгрөг хүртэлх дүн бүхий зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлд батлан даалт гаргах, холбогдох батлан даалтын гэрээг АХБ-тай байгуулахыг Компанид зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар Хавсралт 1-т заасан хөрөнгүүдийг АХБ эсхүл түүнийг албан ёсоор төлөөлөх нэрлэн заасан этгээдэд барьцаалуулах, холбогдох барьцааны гэрээг байгуулахыг Компанид зөвшөөрсүгэй.
3. 2023 оны 3 дугаар сарын 1-ний өдөр Компани болон Таван Богд Холдингс ХХК нарын хооронд байгуулагдсан, 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр нэмэлт өөрчлөлт орсон 2026.01-111 тоот Зээлийн шугамын гэрээний дагуу зээлдүүлэгчийн хувиар Компанийн эдлэх аливаа шаардах эрх, төлбөрийн шаардлагыг энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан АХБ-аас Таван Богд Холдингс ХХК-д олгох зээлтэй холбоотой АХБ-ны аливаа шаардах эрх, төлбөрийн шаардлагын дараа эрэмбэлэх тохиролцоо хийж, шаардах эрхийн дараалал хойшлуулах тухай гэрээ (Deed of Subordination)-г АХБ болон Таван Богд Холдингс ХХК-тай байгуулахыг үүгээр тус тус зөвшөөрсүгэй.
4. Энэхүү тогтоолын 1, 2 болон 3 дахь хэсгүүдэд заасан батлан даалт, барьцаа, шаардах эрхийн дараалал хойшлуулах тухай гэрээний нөхцөл, агуулгыг Компанийн нэрийн өмнөөс хэлэлцэн тохиролцох, барьцаа хөрөнгө нэмэгдүүлэх шаардлагатай тохиолдолд өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх, улмаар тус батлан даалт, барьцаа, шаардах эрхийн дараалал хойшлуулах гэрээнд Компанийг төлөөлж гарын үсэг зурах, баталгаажуулах, эдгээр гэрээтэй холбоотой мэдэгдэл, гэрчилгээ, маягт, хавсралт болон бусад баримт бичигт гарын үсэг зурах, холбогдох төлбөр тооцоог хийх эрхийг дангаараа эсхүл хамтран хэрэгжүүлэх эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Амарсайхан), Таван Богд Холдингс ХХК-ийн Санхүү удирдлага хариуцсан захирал (Б.Оргил) нарт тус тус олгосугай.
5. Энэхүү тогтоолын 1, 2 болон 3 дахь хэсгүүдэд заасан хэлцлүүд нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тул тэдгээрийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн сонирхлын зөрчилгүй, хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар зөвшөөрч, баталсугай.

2016 он 08 сар 18 өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:







Д.ГЭРЭЛМАА

Р.САРАНЦЭЦЭГ

Д.ХҮРЭЛБААТАР